

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.02.19



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.345%	5.08%
Хүннү	2028.01.19	8.65%	6.445%
Монгол 29	2029.06.05	7.87%	6.71%
Монгол 31	2031.07.07	5.34%	6.95%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 500 сая ам.долларын шинэ бонд гаргахаар шийдвэрлэж, түүний өгөөжийн түвшинг 6.625 хувь дээр тогтоолоо. Энэхүү шинэ бонд 2-р сарын 25 өдрөөс эхлэн арилжаалагдана.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Хөгжлийн банк (DEVBM)	2026.03.07	11.00%	7.67%
Энержи Ресурс (MMC)	2026.09.13	12.50%	6.44%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	10.89%
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.56%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.44%-10.89%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

ЯМАР КОМПАНИЙН “БОНД”-ЫГ СОНГОХ ВЭ?

2022 оноос хойш биржийн бус зах зээлд 3.1 их наяд төгрөгийн бонд бүртгэгдсэнээс 2024 оны байдлаар 1.5 их наяд төгрөгийн бондыг Голомт Капитал компани дангаар андеррайтер хийсэн байна. Бид санхүү, уул уурхай, үйлдвэрлэл зэрэг салбарын бондыг хөрөнгө оруулагчдад санал болгож ирсэн туршлагатай.

Мөн бид 2024 онд нийт 294 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийг харилцагчийн дансанд 1 ч хоногийн хоцролтгүйгээр амжилттай олгоод байна.

Тиймээс та өөрийн хүссэн салбарын бондод хөрөнгө оруулах боломжийг Голомт Капитал санал болгож байна.



Н.ДАНЗАНДАГВА
/Арилжааны газрын
захирал/



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын 20 жилийн засгийн газрын бондын өгөөж 4.824%-д тогтворжиж, 4.680%-ийн дэмжлэгийн түвшнээс дээш өслөө. Өмнө нь 5.08%-ийн эсэргүүцлийг сорьсон ч давж чадаагүй нь богино хугацаанд өсөлтийн хязгаар байгаа гэдгийг илтгэж байна. Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүг яаран бууруулахгүй гэсэн шийдвэр болон Трампын тарифын нөлөөнөөс шалтгаалан 5.08% болон 5.42%-руу өсөх боломжтой.

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж




Эх сурвалж: Tradingview



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

График 2. Биржийн бус зах зээлийн арилжаа (Тэрбум төгрөг)



Тайлант хугацаанд биржийн бус зах зээлд нийт 95 компанийн 131 өрийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Үүнээс 1,781.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 1,670.2 тэрбум төгрөгийг бодитоор татан төвлөрүүлсэн байна.

Мөн 91.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 71.9 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн гэж тайлагдсан байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

Биржийн бус зах зээл дээр нийт 317,520 ширхэг үнэт цаас нийт 66,087,867,932 төгрөгийн үнээр, мөн 205 ширхэг үнэт цаас 1,005,180.47 ам.доллараар арилжаалагдсан байна. Үүнээс анхдагч зах зээлд 164,300 ширхэг үнэт цаас нийт 27,050,000,000 төгрөгөөр арилжаалагдсан бөгөөд 200 ширхэг үнэт цаас 1,000,000 ам.доллараар худалдаалагджээ. Харин хоёрдогч зах зээлд 153,220 ширхэг үнэт цаас 39,037,867,932 төгрөгийн дүнтэй, 5 ширхэг үнэт цаас 5,180.49 ам.доллараар арилжаалагдсан байна.

Биржийн бус зах зээлийн Бүртгэлийн хороо нь 2025.02.10-ны өдрөөс 2025.02.14-ний өдрийн хооронд 1 удаа ээлжит, 2 удаа ээлжит бусаар хуралдаж, 2 үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, 2 үнэт цаасыг бүртгэлээ.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



БОНДЫН ЗӨВЛӨХҮҮД

8665-1177 | 8665-4422 | 8083-6622 | 8888-9183